



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/151/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Хотын нэр оруулах)

2019 он

Тэргүүлэх аудитор:

Утас: Цахим хаяг:

Аудитын менежер:

Утас: Цахим хаяг:

Аудитор:

Утас: Цахим хаяг:

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал..... Error! Bookmark not defined.	
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11	Шилэн дансны мэдээлэл	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3	Менежментийн захидал Error! Bookmark not defined.	
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	8

1 Аудитын гэрчилгээ

Батлагдсан гэрчилгээ скайннердаж энд оруулах

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Албаны дарга М.Батбаярт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.24-нөөс 2019.02.25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын Гэрээт аудитор Ж.Чогсомжанлав хариуцаж хэрэгжүүлэв.

Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.02.15 БНА-2019/153/СТА-ТШЗ

-ны өдрийн 18 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба нь Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлсэн загвар аймаг болж, аймгийн нийгэм эдийн засгийн хөгжилд аялал жуулчлалаас оруулах үр өгөөжийг нэмэгдүүлнэ гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба нь гадаад харилцаа, аялал жуулчлалын хөгжлийн стратеги бодлогыг боловсруулах, аялал жуулчлалын салбарт үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий үйлчилгээний байгууллагууд болон гадаадын төсөл хөтөлбөрийн байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулах, зөвлөгөө дэмжлэгээр хангах, хяналт шинжилгээ үнэлгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 50 оноо авсан тул мэдээлэл технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай

илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж санал дүгнэлт гаргахад шаардлагатай материаллаг байдлын түвшинг урьдчилсан байдлаар тооцохдоо суурь үзүүлэлтийг үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгох нь зохимжтой гэж үзэв.

Гүйцэтгэлийн шатанд шинж чанарын болон орчин нөхцөлийн хувьд материаллаг байдал илрээгүй болно. Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны 2018 оны нийт зардал 65,3 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 1,3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, Маягт № Б201-ээр баримтжуулан баталгаажуулав.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчил илрээгүй, залруулга хийгдээгүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд

захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 63875,2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 63875,2 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн “ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн аудит”-таар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллийг хугацаанд нь ,6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлогын 5 гүйлгээ байгааг хугацаанд тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Зөвлөмж өгөөгүй.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Гадаад харилцаа, аялал жуулчлалын албаны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Гадаад харилцаа аялал жуулчлалын албаны 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	210,094.00	6,553,794.00
33	АВЛАГА	32,094.00	31,894.00
335	Бусад авлага	32,094.00	31,894.00
3351	Байгууллагаас авах авлага	32,094.00	31,894.00
34	УРЬДЧИЛГАА	138,000.00	300,000.00
3471	Урьдчилгаа тооцоо	138,000.00	300,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	00.00	300,000.00
34714	Томилолтын урьдчилгаа	138,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	40,000.00	6,221,900.00
354	Хангамжийн материал	40,000.00	6,221,900.00
35410	Бичиг хэргийн материал	00.00	142,900.00
35420	Аж ахуйн материал	40,000.00	6,079,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,649,952.48	6,169,957.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,649,952.48	6,169,957.44
392	Биет хөрөнгө	6,649,952.48	5,949,957.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,999,950.00	6,999,950.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-349,997.52	-1,049,992.56
393	Биет бус хөрөнгө	00.00	220,000.00
39301	Програм хангамж	00.00	220,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,860,046.48	12,723,751.44
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	465,939.00	1,645,739.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	465,939.00	1,645,739.00
413	Өглөг	465,939.00	1,645,739.00
4136	Бусад өглөг	00.00	1,179,800.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	1,179,800.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,394,107.48	11,078,012.44
51	Засгийн газрын хувь оролцоо	6,394,107.48	11,078,012.44
512	Хуримтлагдсан үр дүн	6,394,107.48	11,078,012.44
51210	Өмнөх үеийн үр дүн	6,394,107.48	6,394,107.48
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	4,683,904.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,860,046.48	12,723,751.44

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	56,668,900.00	69,988,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	56,668,900.00	69,988,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	6,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	6,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	56,668,900.00	63,988,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	56,668,900.00	63,988,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	50,274,792.52	65,304,695.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,274,792.52	65,304,695.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,471,651.52	63,661,515.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,836,348.00	50,012,290.00
210101	Үндсэн цалин	38,836,348.00	50,012,290.00

Гадаад харилцаа аялал жуулчлалын албаны 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,271,997.00	6,164,066.00
210201	Тэтгэврийн даатгал	4,271,997.00	6,164,066.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,065,809.00	3,484,164.00
210401	Бичиг хэрэг	379,200.00	1,077,869.00
210402	Тээвэр, шатахуун	370,500.00	1,513,220.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,316,109.00	893,075.00
2107	Томилолт, зочны зардал	2,947,500.00	2,966,000.00
210702	Дотоод албан томилолт	2,947,500.00	2,966,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	335,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	335,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	349,997.52	699,995.04
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	349,997.52	699,995.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,803,141.00	1,643,180.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,800,000.00	1,529,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,529,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,141.00	113,380.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,141.00	113,380.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	6,394,107.48	4,683,904.96

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	56,668,900.00	69,988,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	56,668,900.00	69,988,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	6,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	6,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	56,668,900.00	63,988,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	56,668,900.00	63,988,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	56,668,900.00	69,988,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	56,668,900.00	69,988,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,865,759.00	68,345,420.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,536,200.00	50,315,556.00
210101	Үндсэн цалин	38,536,200.00	50,315,556.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,138,300.00	6,049,400.00
210201	Тэтгэврийн даатгал	4,138,300.00	6,049,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,105,809.00	3,777,264.00
210401	Бичиг хэрэг	386,700.00	1,174,390.00
210402	Тээвэр, шатахуун	363,000.00	1,513,220.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,356,109.00	1,089,654.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,999,950.00	00.00
210602	Тавилга	999,950.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,000,000.00	00.00

Гадаад харилцаа аялал жуулчлалын албаны 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	3,085,500.00	1,648,200.00
210702	Дотоод албан томилолт	3,085,500.00	1,648,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	6,555,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	6,555,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,803,141.00	1,643,180.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,800,000.00	1,529,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,529,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,141.00	113,380.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,141.00	113,380.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	6,394,107.48	00.00	6,394,107.48
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	6,394,107.48	00.00	6,394,107.48
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	4,683,904.96	00.00	4,683,904.96
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	11,078,012.44	00.00	11,078,012.44

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	56,668,900.00	56,665,759.00	63,875,220.00	63,875,220.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	56,668,900.00	56,665,759.00	63,875,220.00	63,875,220.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,868,900.00	54,865,759.00	62,345,420.00	62,345,420.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,539,200.00	38,536,200.00	50,315,556.00	50,315,556.00
210101	Үндсэн цалин		00.00	50,315,556.00	50,315,556.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,138,300.00	4,138,300.00	6,049,400.00	6,049,400.00
210201	Тэтгэврийн даатгал	4,138,300.00	41,383,000.00	6,049,400.00	6,049,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,105,900.00	2,105,809.00	3,777,264.00	3,777,264.00
210401	Бичиг хэрэг	386,700.00	386,700.00	1,174,390.00	1,174,390.00
210402	Тээвэр, шатахуун	363,000.00	363,000.00	1,513,220.00	1,513,220.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,356,200.00	1,356,109.00	1,089,654.00	1,089,654.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,000,000.00	6,999,950.00	00.00	00.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,000,000.00	999,950.00	00.00	00.00
210602	Тавилга	00.00	6,000,000.00	00.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	3,085,500.00	3,085,500.00	1,648,200.00	1,648,200.00
210702	Дотоод албан томилолт	3,085,500.00	30,855,000.00	1,648,200.00	1,648,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	00.00	555,000.00	555,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	00.00	555,000.00	555,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1800000.00	1800000.00	1529800.00	1529800.00

Гадаад харилцаа аялал жуулчлалын албаны 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	1,800,000.00	1,800,000.00	1,529,800.00	1,529,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,800,000.00	1,800,000.00	1,529,800.00	1,529,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	56,668,900.00	56,665,759.00	63,988,600.00	63,875,220.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	63,988,600.00	63,875,220.00
132001	Орон нутгийн төсвөөс	56,668,900.00	56,665,759.00	63,988,600.00	63,875,220.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	00.00	00.00	06.00	06.00
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00	05.00	05.00